

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/170/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Назгүл Утас: 99427301 Цахим хаяг: nazguld@ audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
Байхгүй .....	17
4.3 Албан шаардлага .....	17
4.4 Зөвлөмж .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Н.ЕРЛАН ТАНАА

2022.02.07 № 18  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Statistikiin heltes-dugnelt-2.07

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

Statistikiin heltes-dugnelt-2.07

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

			Төгрөгөөр	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,559,522.00</b>	<b>1,909,522.00</b>	
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,559,522.00	1,909,522.00	
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,559,522.00	1,909,522.00	
35420	Аж ахуйн материал	1,559,522.00	1,909,522.00	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>23,690,214.52</b>	<b>24,860,048.28</b>	
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	23,690,214.52	24,860,048.28	
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	23,690,214.52	24,860,048.28	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,000,000.00	9,000,000.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,000,000.00)	(9,000,000.00)	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	61,006,284.75	68,919,684.75	
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,484,035.11)	(45,264,061.23)	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,789,200.00	11,789,200.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,621,235.12)	(10,584,775.24)	
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-	
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)	
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>25,249,736.52</b>	<b>26,769,570.28</b>	
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-	
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>25,249,736.52</b>	<b>26,769,570.28</b>	
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	25,249,736.52	26,769,570.28	
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	25,249,736.52	26,769,570.28	
51210	Өмнөх үеийн үр дүн	25,249,736.52	25,249,736.52	
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,519,833.76	
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>25,249,736.52</b>	<b>26,769,570.28</b>	

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			Төгрөгөөр	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>379,382,973.00</b>	<b>225,629,099.00</b>	
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>21,357,032.00</b>	<b>10,876,786.00</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,073,051.00	10,876,786.00	
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,073,051.00	10,876,786.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,073,051.00	10,876,786.00	
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	20,283,981.00	-	
122001	Хандив тусламж /дотоод/	20,283,981.00	-	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>358,025,941.00</b>	<b>214,752,313.00</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	106,271,800.00	106,546,300.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	106,271,800.00	106,546,300.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	251,754,141.00	108,206,013.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,300,000.00	9,898,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	249,429,141.00	96,367,433.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,000.00	1,940,580.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>360,296,520.34</b>	<b>224,109,265.24</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>360,296,520.34</b>	<b>224,109,265.24</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	359,100,820.34	223,818,065.24	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	129,389,181.00	118,599,496.00	
210101	Үндсэн цалин	94,941,781.00	85,526,896.00	
210102	Нэмэгдэл	23,731,300.00	23,922,800.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,753,200.00	4,579,200.00	
210104	Урамшуулал	5,962,900.00	4,570,600.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,940,525.00	15,120,775.00	
210201	Тэтгэврийн даатгал	12,352,525.00	11,501,375.00	

210202	Тэтгэмжийн даатгал	897,000.00	904,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	717,600.00	723,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	179,400.00	181,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,794,000.00	1,809,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,423,300.00</b>	<b>20,281,260.00</b>
210401	Бичиг хэрэг	789,200.00	945,100.00
210402	Тээвэр, шатахуун	13,885,000.00	16,171,160.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,462,100.00	2,759,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	287,000.00	406,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,979,500.00</b>	<b>15,052,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,979,500.00	15,052,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>177,563,086.00</b>	<b>44,879,068.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	176,354,470.00	43,717,416.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	54,400.00	54,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.00	56,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	10,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,088,216.00	1,041,252.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,805,228.34</b>	<b>9,885,466.24</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,141,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,805,228.34	6,743,566.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,195,700.00</b>	<b>291,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>664,000.00</b>	<b>291,200.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	664,000.00	291,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>531,700.00</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	531,700.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>19,086,452.66</u></b>	<b><u>1,519,833.76</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>19,086,452.66</u></b>	<b><u>1,519,833.76</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

			Төгрөгөөр
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		25,249,736.52	25,249,736.52
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		25,249,736.52	25,249,736.52
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	25,249,736.52	25,249,736.52
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
Тайлант үеийн үр дүн		1,519,833.76	1,519,833.76
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	26,769,570.28	26,769,570.28

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>358,025,941.00</b>	<b>214,752,313.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>358,025,941.00</b>	<b>214,752,313.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	106,271,800.00	106,546,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	106,271,800.00	106,546,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	251,754,141.00	108,206,013.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,300,000.00	9,898,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	249,429,141.00	96,367,433.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,000.00	1,940,580.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>354,025,941.00</b>	<b>214,752,313.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>354,025,941.00</b>	<b>214,752,313.00</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>352,830,241.00</b>	<b>214,461,113.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	125,542,601.00	118,599,496.00
210101	Үндсэн цалин	92,661,501.00	85,526,896.00
210102	Нэмэгдэл	23,731,300.00	23,922,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	4,579,200.00
210104	Урамшуулал	4,570,600.00	4,570,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,940,525.00	15,120,775.00
210201	Тэтгэврийн даатгал	12,352,525.00	11,501,375.00
210202	Тэтгэмжийн даатгал	897,000.00	904,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	717,600.00	723,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	179,400.00	181,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,794,000.00	1,809,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,759,249.00	19,377,974.00
210401	Бичиг хэрэг	513,200.00	473,700.00
210402	Тээвэр, шатахуун	13,491,949.00	15,739,274.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,462,100.00	2,759,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	292,000.00	406,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	15,979,500.00	15,052,000.00
210702	Дотоод албан томилолт	15,979,500.00	15,052,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	179,608,366.00	43,168,968.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	178,053,266.00	41,820,916.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	54,400.00	54,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.00	56,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	10,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,434,700.00	1,227,652.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	3,141,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,141,900.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,195,700.00	291,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	664,000.00	291,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	664,000.00	291,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	531,700.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	531,700.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>4,000,000.00</b>	<b>-</b>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,000,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,000,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	4,000,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,000,000.00	-
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>(4,000,000.00)</b>	<b>-</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	106,546,300.00	106,546,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,546,300.00	106,546,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,255,100.00	106,255,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,484,000.00	90,484,000.00
210101	Үндсэн цалин	57,411,400.00	57,411,400.00
210102	Нэмэгдэл	23,922,800.00	23,922,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	4,579,200.00

210104	Урамшуулал	4,570,600.00	4,570,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	12,215,400.00	12,215,400.00
210201	Тэтгэврийн даатгал	8,596,000.00	8,596,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	904,800.00	904,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	723,900.00	723,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	181,000.00	181,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,809,700.00	1,809,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,227,900.00	2,227,900.00
210401	Бичиг хэрэг	473,700.00	473,700.00
210402	Тээвэр, шатахуун	718,200.00	718,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	630,000.00	630,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	406,000.00	406,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,045,900.00	1,045,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000.00	198,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,400.00	54,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.00	56,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	10,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	727,500.00	727,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	281,900.00	281,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	281,900.00	281,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	291,200.00	291,200.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	291,200.00	291,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	291,200.00	291,200.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	106,546,300.00	106,546,300.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	106,546,300.00	106,546,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	106,546,300.00	106,546,300.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	6.00	6.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5.00	5.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	1.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>108,206,013.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>108,206,013.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	108,206,013.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	28,115,496.00
210101	Үндсэн цалин	28,115,496.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,905,375.00
210201	Тэтгэврийн даатгал	2,905,375.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,150,074.00
210402	Тээвэр, шатахуун	15,021,074.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,129,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	15,052,000.00
210702	Дотоод албан томилолт	15,052,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	42,123,068.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,622,916.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,152.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,860,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,860,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	108,206,013.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	108,206,013.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,898,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,367,433.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,940,580.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Тус хэлтэс нь аймгийн эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд адил тэгш үйлчлэх зорилготой үйл ажиллагаа явуулдаг.

Статистикийн хэлтэс нь: Албан ёсны статистикийн мэдээний бодит байдлыг сайжруулах, өрхөд суурилсан түүвэр судалгааны хамралтыг сайжруулах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Үндэсний статистикийн хорооны Дотоод аудит эрсдэлийн удирдлагын газраас санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийж заавар, зөвлөгөө өгч ажилладаг байна. Тус газарт 2021 онд дээрх газраас дотоод аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 360.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Статистикийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.5 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	1,559.5	1,909.5	350.0
Үндсэн хөрөнгө	23,690.2	24,860.0	1,169.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>25,249.7</b>	<b>26,769.5</b>	<b>1,519.8</b>
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	25,249.7	26,769.5	1,519.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>25,249.7</b>	<b>26,769.5</b>	<b>1,519.8</b>

Мөнгөн хөрөнгийн болон авлагын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1.9 сая төгрөг болж 0.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 27.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй 2.9 сая төгрөгийн бараа материал хүлээн авч үйл ажиллагаандаа 30.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24.8 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 7.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 6.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 26.7 сая төгрөг болж 1.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1.5 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Статистикийн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 225.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 153.7 сая төгрөгөөр буюу 40.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нэмэлт санхүүжилтийн орлого байна. Нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 143.5 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 136.2 сая төгрөгөөр буюу 37.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, хангамж, бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Цалин, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд өнөх оноос буурсан бол хангамж, бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 106.3 сая төгрөг, тодотгосон төсөв 106.6 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 0.3 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Үүнд: цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж бараа материалын зардлыг 0.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 0.04 сая, урсгал шилжүүлгийг 0.07 сая төгрөгөөр буюу нийт 0.61 сая төгрөгөөр бууруулж тодотгол хийгдсэн байна.

Шалтгаан нь: 2021 оны төсвийг Үндэсний Статистикийн хорооноос 2020 оны төсвийн гүйцэтгэлээр анх баталсан бөгөөд 2021 онд хэлтсийн 3 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл, 2 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 1 албан хаагчид Улсын байцаагчийн эрх олгож, ТЗ-5-аас ТЗ-6 болгож цалингийн шатлал ахиулсан, мөн нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэдэг зохион байгуулагч гэдэг албан тушаалаар ажилладаг албан хаагч нь ТҮ-6-аар цалинждаг байсан бол үүнийг нягтлан бодогч гэж өөрчлөн ТҮ-7-оор цалинжуулсантай холбогдуулан жилийн эхэнд баталсан төсвийн цалингийн сан хүрэлцэхгүй байсан тул анх батлагдсан төсөвт тодотгол хийж цалингийн зардлыг нэмэгдүүлэн, бусад зардлыг танасан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 106.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 106.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуул судалж үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 9.9 сая, дээд шатны төсвийн захирагчаас 96.4 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 1.9 сая, нийт 108.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 28.1 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 2.9 сая, хангамж бараа материалын зардалд 17.1 сая, томилолт, зочны зардалд 15.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 42.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 2.9 сая, нийт 108.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Статистикийн хэлтэс 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 117 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад алдаа зөрчил илрээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувьтай байна.

### **3.9.2**

#### **Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Статистикийн хэлтэс нь 2021 онд 106.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр, төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

### **4.3 Албан шаардлага**

Байхгүй

### **4.4 Зөвлөмж**

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн